

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛ: ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ, ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б.Хишигсайхан, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Цагдаагийн албаны тухай хууль 2013 онд шинэчлэн батлагдсанаар цагдаагийн үйл ажиллагааг иргэний хяналтад оруулж, иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг болгох, тэдний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах эрх зүйн үндсийг тогтоосон билээ. Тус зорилтын хүрээнд аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэд Иргэний зөвлөл /ИЗ гэх/-тэй байхаар тусгасан бөгөөд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, сургалт, үйл ажиллагаандаа орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээлгэсэн юм. Энэ нь цагдаагийн байгууллага хүний

эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, олон нийтийн итгэлийг хүлээж, иргэний дэмжлэгийг авах үйл ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх чухал механизм билээ. Мөн олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг тус хуулиар зохицуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий олон нийтийн цагдаагийн ажилтан /ОНЦА гэх/-аар ажиллах гэрээг иргэдтэй байгуулж ажиллуулах болсон юм. ОНЦА-ы урамшуулал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хувцас, холбооны болон тусгай хэрэгсэл, сургах зардлыг нутгийн удирдлага хариуцахаар зохицуулсан. ИЗ, ОНЦА-ы үйл ажиллагаа хуулийн дагуу, үр нөлөөтэй явагдаж чадах эсэхээс цагдаагийн албаны шинэчлэл ихээхэн хамаарна.

Тиймээс ННФ цагдаагийн шинэчлэлийн хүрээнд шинээр бий болсон бүтцийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор ТББ-уудад мониторингийн тэтгэлэг олгосон билээ. Тус мониторингид аймаг, нийслэлийн 31 ТББ хамрагдсан бөгөөд Улаанбаатар хот, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Завхан, Сэлэнгэ, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл аймгийг хамруулсан юм. 2015 оны байдлаар Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу нийслэл болон ихэнх аймаг ИЗ-өө байгуулж, ОНЦА-ыг томилон ажиллуулжээ. Энэ ажилд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагууд хүчин чармайлт гаргаж байгаа бол нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагууд голдуу хойрго хандаж байна. Ер нь ИЗ, ОНЦА-ны талаарх ойлголт,

Б.ХИШИГСАЙХАН



ННФ-ын засаглалын хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн шинэчлэлийг дэмжих, хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэх, стратегийн өмгөөллийг хөгжүүлэх асуудлыг хариуцан ажилладаг. Тэрээр хүний эрхийн хууль, эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хүний эрхийн боловсрол, эрх зүйн чадавхыг нэмэгдүүлэх асуудал, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах ажиллагааны зохицуулалт зэрэг олон асуудлаар мэргэшин ажиллаж, энэ чиглэлээр судалгааны ажил, ном товхимол хэвлүүлж байв. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай, Нийтийн сонсголын тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны ерөнхий хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай. Б.Хишигсайхан нь эрх зүйн бакалаврын зэргээ МУИС-ийн Хууль зүйн сургуульд, хүний эрхийн хуулийн магистрын зэргээ Хонгконгийн Их Сургуульд /HKU/ тус тус хамгаалсан.

мэдлэг орон нутгийн удирдлага, иргэдийн дунд төлөвшөөгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж болох юм. Үүний зэрэгцээ Иргэний зөвлөлийн гишүүд, олон нийтийн цагдаагийн ажилтанд урамшуулал олгоогүй, эсвэл алдаг оног олгож байснаас гадна олгож байсан урамшууллыг төсөв байхгүй гэсэн үндэслэлээр зогсоосон аймаг ч байна. Үүний шалтгааныг санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой заагаагүй, эсхүл орон нутаг санхүүжүүлэх төсөв хөрөнгө байхгүй хэмээн тайлбарлаж байна. Гэсэн хэдий

ч ИЗ, ОНЦА ажилласнаар зарим эерэг үр дүн гарчээ. Тухайлбал, Орхон аймгийн ИЗ нь цагдаагийн байгууллагад хандан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар, мөн цагдаагийн алба хаагчдын ээлжийн амралтын мөнгийг хугацаанд нь олгож байхыг зөвлөж, асуудлыг шийдүүлсэн бол Дархан-Уул аймгийн Цагдаагийн хэлтэс ИЗ-өөс ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн “Хүүхдийн алба”-ыг “Хүүхэд, гэр бүл, хүчирхийлэлтэй тэмцэх тасаг” болгон өргөжүүлжээ. Судалгаанд хамрагдсан бүх албан тушаалтан, иргэд ОНЦА

ажилласнаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалахад ахиц гарч байна гэж дүгнэсэн юм.

Мониторингийн хүрээнд цуглуулсан мэдээлэлд тулгуурлан цагдаагийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх хүрээнд ИЗ, ОНЦА-ы үйл ажиллагааг эрчимжүүлэх, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг засаж сайжруулах зөвлөмжийг боловсруулан энэхүү Бодлогын асуудлаар олон нийтэд хүргэж байна. Мониторинг тус бүрийн дэлгэрэнгүй тайланг www.fogum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

А. Цагдаагийн албаны тухай хуульд орсон шинэчлэлтийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр

1. Цагдаагийн албаны шинэчлэлийн үзэл баримтлал, зохицуулалтын талаар холбогдох талууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх

Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд ИЗ, ОНЦА-ны тухай ойлголт муутайгаас үйл ажиллагаагаа явуулах орчин нөхцөл, санхүүжилтийг шийдэхгүй байх нь нийтлэг тохиолдож байгаа бөгөөд ийм бүтэц шаардлагагүй гэх хандлага ч гарч байна. Үүний зэрэгцээ иргэд, иргэний нийгмийн байгууллага нь ИЗ-ийн талаар ойлголт, мэдлэг муутайгаас нэрээ дэвшүүлэхгүй байгаа нь 1 300 000 мянга орчим хүн амтай нийслэлээс гэхэд 14 хүн л нэрээ дэвшүүлснээс харагдаж байна. Энэ байдал бусад орон нутгийн хувьд ч мөн ижил. Түүнчлэн иргэд нэр дэвшигчдэд санал өгөхдөө ч тун хойрго байна. Үүний зэрэгцээ иргэд ОНЦА-д “мөрөөдлийн цагдаа”, “цэрэгжсэн цагдаа”, “бууны нохой” гэх мэт нэр хоч өгснөөс харахад энэ тухай мэдлэг ойлголт хангалтгүй байгааг харуулж байна. Шалтгаан нь ОНЦА цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд зөрчлийг илрүүлж, энэ тухай цагдаагийн албан тушаалтанд мэдэгдэж ажиллаж байгаа нь

зарим хүмүүсийн дургүйцлийг төрүүлсэнтэй ч холбоотой байж болох юм. Энэ бүхнээс дүгнэхэд холбогдох бүх талууд цагдаагийн шинэчлэлийг нэг мөр ойлгож байж, хууль үр дүнтэй хэрэгжих бодит боломж бүрдэнэ.

2. Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу шинээр бий болсон ИЗ, ОНЦА-ны үйл ажиллагааны санхүүжилтийг аймаг, нийслэлийн түвшинд бүрэн шийдвэрлэхэд шаардлагатай нэгдсэн удирдамжийг холбогдох талуудын оролцоотой боловсруулж хүргүүлэх, хуулийг хэрэгжүүлэх талаар Сангийн яамтай зөвшилцөлд хүрэх

Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйлийн 21.9, 24-р зүйлийн 24.9-т санхүүжилтийн тухай заасан ч орон нутаг төсвийн асуудлыг шийдвэрлэхэд энэ заалт нь хангалттай эрх зүйн үндэслэл болж чадахгүй байна гэж нутгийн удирдлага үзэж байна. Учир нь төсвийн төсөлд тухайн зардлыг тусгаад явуулж байгаа ч Сангийн яам хасаад баталчихдаг ажээ. Үүний зэрэгцээ ИЗ, ОНЦА-ны санхүүжилтийг төсвийн аль ангилалд оруулах нь тодорхойгүй байгаа нь мөн хүндрэл учруулж байна. Төсвийн хүндрэлтэй холбоотой цалингаас бусад санхүүжилтийг зогсоох шийдвэр

гарах үеэр ИЗ, ОНЦА-ны урамшууллыг олгох боломжгүй болжээ. Мөн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр холбогдох хуультай зөрчилдсөн шийдвэр гаргасан тохиолдол ч байна.

Энэ бүхнээс дүгнэхэд санхүүжилтийг хэрхэн шийдэх талаар орон нутагт нэгдсэн удирдамж хүргүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна.

Б. Иргэний зөвлөлийн сонгон шалгаруулалтыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр

1. Иргэний зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг үр нөлөөтэй зохион байгуулах зохицуулалтын хувилбаруудыг орон нутагт санал болгож, арга хэлбэрээ өөрсдөө сонгох боломжийг олгох

Дүрэмд зааснаар ИЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нийтдээ 61 хоног үргэлжлэхээр байгаагийн зэрэгцээ нэр дэвшсэн хүмүүст иргэдээс санал авах ажлыг “цахим хуудсаар”, “сумын ИТХ, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар явуулна” гэж тусгажээ. Харин иргэдээс санал авахдаа дээрх хоёр аргыг хоёуланг нь ашиглах уу, эсхүл аль нэгийг сонгох боломжтой юу гэдгийг дүрэмд тодорхой заагаагүй. Тиймээс зарим аймаг зөвхөн цахимаар санал авсан бол цөөн аймаг ИТХ, ИНХ-аас санал авч, үлдсэн нь аль аль хэлбэрийг ашиглажээ. Сум, дүүрэг, баг, хорооны иргэдийн саналыг ИТХ, ИНХ-аар дамжуулан авахаар байгааг зарим аймаг, нийслэлийн удирдлагаас ихээхэн хүндрэлтэй шат дамжлага хэмээн шүүмжилсэн. Магадгүй энэ байдлаар санал авах бол хүн ам ихтэй аймаг, нийслэлийн хувьд дүрмийн хугацаанд энэ ажлыг амжуулахааргүй дүр зураг харагдаж байгаа юм. Мөн түүнчлэн цахим хуудсаар санал авах ажлыг хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй байна гэж орон нутгийн Сонгон шалгаруулах комиссын зарим гишүүд шүүмжилж байна. Мониторингид хамрагдсан газраас зөвхөн нийслэл Вижуалайзд девелопмент ХХК-тай гэрээлж цахим сонгуулийн програм хангамж ашигласан бол Орхон аймаг нэг IP хаягаас нэг санал авна гэсэн дүрэм тогтоожээ. ИЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах олон хувилбараас аймаг, нийслэл нь сонголт хийхээр дүрэмд өөрчлөлт оруулах нь энэ чиглэлээр орон нутгийн санаачилгыг нэмэгдүүлэхэд тустай байж болох юм. Сонгон шалгаруулалтын гол үр дүн бол хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх бүхий ИЗ байгуулах явдал тул сонгосон хувилбар нь үр дүнтэй байсан эсэхийг хөндлөнгийн мониторинг хийх замаар тодорхойлох боломжтой.

Өөр нэг асуудал бол ИЗ-ийн гишүүн хугацаанаас өмнө ажлаас чөлөөлөгдөх тохиолдолд дараагийн хүнийг тухайн гишүүний үлдсэн хугацаанд ажиллахаар нөхөн томилно гэсэн ч хэрхэн сонгон шалгаруулахыг заагаагүй. Тиймээс ИЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах бүх үе шатыг баримтлан томилохоор байгаа нь хугацаа алдсан, хөрөнгө хүч үргүй зарцуулах зохицуулалт болоод байна. Тиймээс үүнийг нөхөж зохицуулах шаардлагатай.

2. Иргэний зөвлөлийн гишүүдийн анхны томилгоог хуульд нийцүүлээгүй алдааг залруулах нэмэлт удирдамж өгөх

ИЗ-ийн гишүүдийг ижил хугацаатай томилсон аймгуудын хувьд энэ алдаагаа хэрхэн залруулах нэгдсэн удирдамжийг ХЗЯ-наас холбогдох аймгуудад хүргүүлэх шаардлагатай байна. Ялгаатай хугацаагаар томилоогүй ИЗ-ийн дараагийн сонгон шалгаруулалтыг Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-р зүйлд нийцүүлэн явуулах гэсэн удирдамж хүргүүлэх нь энэ алдааг засах нэг гарц байж болох юм.

3. Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт, гишүүдийн урамшуулал олгох асуудлыг нэг мөр шийдвэрлэх

Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал, гишүүдэд олгох урамшууллыг аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр хуульд заажээ. Ихэнх аймаг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 192000 төгрөгөөр тогтоогоод байгаа бол хууль зөрчиж огт урамшуулал өгөхгүй байгаа аймаг ч байна. Зөвхөн нийслэл ИЗ-ийн гишүүдийн урамшуулалд 375000 төгрөг олгож байна. Аймгууд урамшууллыг олгохдоо ИТХ-ын төсвөөс, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /ГХУСАЗЗ гэх/-ийн зардлаас гэх мэт ялгамжтай байдлаар зохицуулжээ. ИЗ-ийн гишүүдэд урамшуулал

олгох төдийгөөр л санхүүжилтийг шийдэж байгаа практик дийлэнх аймгуудад байна. Гэтэл Цагдаагийн албаны тухай хууль, Иргэний зөвлөлийн дүрэмд заасан тодорхой чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийлгүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад санхүүжилтийн тодорхой эх үүсвэр шаардлагатай юм. Өнөөгийн байдлаар ихэнх ИЗ-ийн үйл ажиллагаа хуралдаан хийх төдийгөөр л хязгаарлагдаж байна. Хэдийгээр аймгууд жилийн төсвийн төсөлд ИЗ-ийн үйл ажиллагааны зардлыг суулгаж өгсөн ч Сангийн яам хасчихдаг байна. Цаашид цагдаагийн шинэчлэлийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох ИЗ-ийн санхүүжилтийг энэ байдлаар үргэлжлүүлбэл хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүйд хүрч, аажмаар хэрэгцээгүй бүтэц хэмээн татан буугдахад хүрч болзошгүй юм.

4. Иргэний зөвлөл үйл ажиллагаагаа ил тод мэдээлэх ажлыг эрчимжүүлэх

Дүрэмд ИЗ нь ажлын 3 өдөрт багтаан хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг, дараа жилийн 1-р сарын 15-ны дотор урамшуулал, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг цахим хуудастаа байршуулна гэж заасан. Гэсэн хэдий ч аль цахим хуудас буюу ИЗ-ийнх үү, ИТХ-ын цахим хуудсанд байршуулах уу гэдгийг хууль, дүрэмд тодорхой заагаагүй. Практикт албан ёсны цахим хуудастай ИЗ байхгүй бөгөөд зарим ИЗ нь ИТХ-ын цахим хуудсанд өөрийн хуудсыг бий болгосон бол зарим нь фэйсбүүк хуудас нээх замаар энэ асуудлыг шийдэх оролдлого хийжээ. Гэвч эдгээр цахим хуудас нь зохион байгуулалт муутай тул хүссэн мэдээллээ олж авахад хэрэглэгчдэд хүндрэлтэй байна. Ямар нэг байдлаар цахим хуудастай болсон ИЗ-ийн цахим хуудаст орж үзвэл мэдээлэл нь цаг үеийн биш, хуульд заасан мэдээлэл бүрэн тавигдаагүй зэрэг зөрчилтэй байна. Мэдээлэл тогтмол тавигдаж эхэлснээр тухайн ИЗ-ийн үйл ажиллагааг дэмжих олон нийтийн дэмжлэг нэмэгдэх сайн талтай. Тиймээс ИЗ-ийн мэдээллийг иргэдэд ил тод болгож байгаа эсэхийг ажил дүгнэх үзүүлэлт болгох, энэ чиглэлээр сайн туршлагыг түгээх зэргээр мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

5. Дүрмийн 5.1.3 /г/-д заасан “гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн санал, хүсэлтийг авах хайрцгийг цагдаагийн байгууллагад байрлуулж, дүн шинжилгээ хийх” гэсэн чиг үүргийг хууль тогтоомжид нийцүүлэх

Цагдаагийн албаны тухай хуулийн 22.1.1-д заасан “цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох”-ыг хориглох заалттай тус дүрмийн гэмт хэрэг, зөрчлийг “шалгах, шийдвэрлэх” үйл ажиллагааны талаарх иргэдийн санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийх гэсэн чиг үүрэг зөрчилдөж байж болзошгүй тул дүрмийн заалт хуульд нийцэж буй эсэхийг нягтлах шаардлагатай юм.

6. Иргэний зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах

ИЗ-ийн гишүүдийг дүрмийн 3.3-т заасны дагуу ИТХ, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зохион байгуулах сургалтад заавал хамруулахаар заасан. Хэдийгээр тухайн сургалтад хамрагдсан ч өөрсдийн чиг үүргийн талаар төдийлөн сайн мэдэхгүй байна. Энэ нь цоо шинэ бүтэц бөгөөд өмнө нь ажиллаж байгаагүй тул ИЗ-ийн гишүүдэд энэ чиглэлээр бусад улс орны туршлага судлах, мөн дотооддоо харилцан туршлага солилцох зэрэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлж болох юм. Тухайлбал, аймаг, нийслэлийн ИЗ-ийн гишүүдийг харилцан туршлага солилцуулах бүсийн, үндэсний хэмжээний арга хэмжээг зохион байгуулах, үүнд цахим хурал зохион байгуулах гэх мэт технологийн дэвшлийг ашиглах замаар зардлыг бууруулах боломжтой. Мөн бусад улс орны туршлагыг таниулах гарын авлага, материалаар ИЗ-ийн гишүүдийг хангах, үүний зэрэгцээ гадаад улсад туршлага судлуулах боломжийг эрэлхийлж ч болох юм.

В. Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр

1. Олон нийтийн цагдаагийн ажилтны санхүүжилтийг хэрхэн шийдэх талаар нэгдсэн удирдамжийг орон нутагт хүргүүлэх

ОНЦА-ы урамшуулал, таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, сургалт явуулахтай холбогдсон зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ хэмээн зохицуулсан. Гэтэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлд ОНЦА-ы урамшууллыг л олгохоор заажээ. Энэхүү хоёр хуулийн зөрчилдөөнөөс үүдэн төсөв байхгүй гэсэн шалтгаанаар хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцсаар хангагдаагүй ОНЦА хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. ОНЦА-ыг сургаж, дадлагажуулахад зориулсан зардлыг нийслэл, зарим аймагт тусгайлан санхүүжүүлсэн бол ихэнх аймагт нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хариуцан явуулсан байна. Цаашид ийм байдлаар үргэлжилбэл, ОНЦА тогтвор суурьшилгүй байгаа өнөө үед 21 хоногийн сургалтыг тухай бүрд зохион байгуулах нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсөвт хүндрэл учруулж болзошгүй юм. Мөн түүнчлэн төсөв байхгүй гэсэн шалтгаанаар сумдаас аймгийн төвд очиж сургалтад суусан ОНЦА-д томилолт олгохгүй байгаа нь тухайн хүмүүст хүндрэл учруулж байна. Үүний зэрэгцээ Дархан-Уул аймаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг бүхэлд нь ОНЦА-ны урамшуулал олгоход зарцуулснаас үүдэн хуулиар хүлээсэн бусад чиг үүргээ санхүүжүүлэх төсөвгүй болжээ. Тиймээс ХЗЯ нь Засгийн газар, Сангийн яамтай хамтран ОНЦА-ны санхүүжилтийг хэрхэн шийдэх талаар ажиллах шаардлагатай байна.

2. Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшууллын асуудлыг оновчтой шийдвэрлэх, илүү цагаар ажилласан тохиолдолд урамшуулал олгох, эсхүл амралтыг биеэр эдлүүлэх

ОНЦА-ы урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоох нь түгээмэл байгаа бөгөөд урамшууллаас шалтгаалан ОНЦА тогтвор суурьшилгүй болж ихээхэн өөрчлөлт хөдөлгөөн гарч байна. Улаанбаатар хот, Орхон аймагт ажлын үр дүнг харгалзан зарим ОНЦА-д

нэмэгдэл урамшуулал олгожээ. Урамшууллыг сумын төсвөөс гаргаж байгаа тохиолдолд ОНЦА нь сумын ЗДТГ-ын ажилд туслалцаа үзүүлэх ёстой гэх буруу хандлага гарч байна. Тиймээс хадлан, тэжээл бэлтгэх болон бусад захиргааны чиг үүргийг гүйцэтгэхийг шаарддаг ажээ. Хуулиар урамшуулал олгоно гэсэн заалтыг аймаг, нийслэлд нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор урамшууллыг оновчтой шийдвэрлэх нэгдсэн удирдамж гаргаж орон нутагт хүргүүлэх шаардлагатай юм. Үүний зэрэгцээ цаг үеийн онцлогоос шалтгаалан ОНЦА нь нийтээр амрах баярын өдөр, амралтын өдрүүдэд болон илүү цагаар ажиллах тохиолдолд урамшууллыг тооцож олгохгүй байна. ОНЦА-ы хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварын 7.3-т “урамшил олгож болно” гэсэн нь заавал биелүүлэх заалт биш захиргааны байгууллагын сонголт болоод байгаа тул Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн “урамшил олгоно” гэж солих нь зүйтэй.

3. Нэг бүрийн, холбооны болон хамгаалах тусгай хэрэгслээр хангах, ОНЦА-ыг энэ чиглэлээр сургаж, дадлагажуулах

Нэг бүрийн, холбооны болон хамгаалах тусгай хэрэгслээр хангахаар зохицуулсан ч ОНЦА хэрхэн хэрэглэхийг журамлаагүй, төсөв байхгүй гэсэн шалтгаанаар мониторинг хийсэн нийт аймагт хангалт огт хийгдээгүй байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 24.7-р зүйлд “холбооны болон хамгаалах тусгай хэрэгсэл тавьж олгоно”, 24.9-р зүйлд “...нэг бүрийн тусгай хэрэгсэл,... зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ.” хэмээн тус тус заасан. Гэсэн хэдий ч одоо мөрдөгдөж байгаа журамд заасан нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгслийг бүгдийг ОНЦА-д олгох уу, энэ тохиолдолд ОНЦА хэрэглэх зохих дадлага туршлагатай юу зэрэг асуулт гарч ирж байна. Тусгай хэрэгслийг хүний эрх, эрх чөлөөнд халдаж хэрэглэдэг тул үүнийг хэрэглэх алба хаагч тусгайлан бэлтгэгдсэн байхын зэрэгцээ хүний эрхийн боловсролтой байх шаардлагатай. Мөн хэрэглэх нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулсан байх учиртай. Гэтэл ОНЦА-ы 21 хоногийн сургалтаар энэ бүх дадлага туршлага олгогдож чадах эсэх нь эргэлзээтэй. Тухайлбал, ОНЦА-ы дүрмийн 4.1-т заасан сургалтын

хөтөлбөрт “нэг бүрийн тусгай хэрэгсэл” хэрхэн хэрэглэх талаар тусгаагүй. Цагдаагийн албаны тухай хуулиар тухайн шатны Засаг дарга нэг бүрийн тусгай хэрэгслийн зардлыг хариуцахаар байтал Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварт цагдаагийн байгууллага хариуцахаар заасан зэрэг зөрчилтэй зохицуулалт байна. Тиймээс ОНЦА-ы нэг бүрийн, холбооны болон хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг гаргах, хэрэглэх журам, нөхцөлийг нарийвчлан тогтоох, ОНЦА нэг бүрийн, холбооны болон хамгаалах тусгай хэрэгслийг хүний эрхийн зарчимд нийцүүлэн ашиглах чадавх олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ОНЦА-ыг тус хөтөлбөрийн дагуу бэлтгэх шаардлагатай байна.

4. ОНЦА нь дүрмийн 2.2.8-д заасан “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад туслалцаа үзүүлж, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн ангилал нь тохирохгүй, эсхүл жолоодох эрхийн үнэмлэхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх” чиг үүргийг хэрэгжүүлэх бодит боломжтой эсэхийг эргэж нягтлах

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад ОНЦА туслалцаа үзүүлж болох хэдий ч зөрчил гаргасан хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хязгаарлахын тулд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, өвчтэй, ядарсан гэдгийг хэрхэн тогтоох талаар бэлтгэгдсэн үү, тусгай хэрэгсэл олгогдсон уу гэдгийг эргэж нягтлах шаардлагатай. Үгүй бол “гар мухар” хүнд хэрэгжүүлэх боломжгүй эрх олгож, улмаар хүний эрхийн зөрчил гарлаа гэхэд хэнтэй, хэрхэн хариуцлага тооцох вэ гэсэн асуулт гарч ирнэ. Тиймээс энэ чиг үүргийг эргэж нягтлах нь зүйтэй.

5. Олон нийтийн цагдаагийн ажилтны хуулиар харьяалуулсан зөрчилд торгууль ногдуулах чиг үүргийг хэрэгжүүлэх

Цагдаагийн албаны тухай хуулийн 24.11.1-д зааснаар ОНЦА нь хуулиар харьяалуулсан зөрчилд торгууль ногдуулахаар заасан ч хууль хэрэгжээд 2 жил болоход мониторингид хамрагдсан газруудад ОНЦА-д торгуулийн хуудас олгоогүй байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 568-р тушаалаар

шинэчлэн батлагдсан Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрмийн 5.3-т энэ чиг үүргийг хэрэгжүүлэх заалтыг нэмж тусгажээ. Гудамжинд гарч буй нийтлэг зөрчлүүдэд торгуулийн шийтгэл ногдуулахаар заасан хэдий ч хууль сахиулагчдын тоо хангалтгүйгээс хуулийг тэр бүр хэрэгжүүлж чаддаггүй. Тухайлбал, хориглосон газар тамхи татах, ил задгай бие засах г.м зөрчлүүд алхам тутамд гарч байдаг. Тиймээс эдгээр зөрчлийг ОНЦА таслан зогсоож, зохих торгуулийн шийтгэлийг ногдуулваас тухайн хэрэг зөрчлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

6. Олон нийтийн цагдаагийн ажилтны хувцасны загвар, чанар, нэр төрлийг эргэж нягтлах, материалыг ажлын онцлог, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх

ОНЦА-ы хувцасны тухайд хавар, намар өмсөх гадуур хувцас олгодоггүйн зэрэгцээ материалын чанар муу, байнга гадаа ажилладаг, халуун наранд байх онцлогийг харгалзаагүй гэсэн шүүмжлэл гарч байна. ОНЦА-ы хөдөлмөр хамгааллын хувцас цагдаагийн алба хаагчийн хувцастай тун төстэй хийгдсэн нь ОНЦА-ы тухай буруу ойлголт төрүүлж байна. Тухайлбал “мөрөөдлийн цагдаа”, “хэт цэрэгжсэн” зэрэг шүүмжийг дагуулж байлаа. Тиймээс ОНЦА-ы хөдөлмөр хамгааллын хувцас, нөр төрөл, материалыг ажлын байрны онцлогт тохируулан шинэчлэх, олон нийтийн санал бодлыг авсны үндсэн дээр загварыг эргэж нягтлах шаардлагатай байна.

7. Олон нийтийн цагдаагийн ажилтныг өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрт ажиллуулах

ОНЦА-ыг амьдран суудаг газраас нь өөр газарт ажиллуулсан тохиолдол мониторингийн явцад ажиглагдав. Энэ нь үр ашиг муутай, цагдаагийн үйл ажиллагааг олон нийтэд түшиглэн явуулна гэсэн шинэчлэлийн бодлоготой нийцэхгүй байна гэсэн шүүмжлэл дагуулж байна. Холбогдох талуудын дүгнэлтээс харахад ОНЦА өөрийн амьдран суудаг газраа ажиллах нь тухайн газар, олон нийтийн талаар илүү ойлголттой байх тул цагдаагийн байгууллагын хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэгт илүү туслалцаа үзүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Тиймээс цаашид ОНЦА-ыг өөрийнх нь оршин суудаг нутаг дэвсгэрт томилж ажиллуулахад анхаарах нь зүйтэй.